

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Сэдэв:	Бизнес регистрийг сайжруулах зөвлөх үйлчилгээ
Төслийн нэр:	Ухаалаг засаг төсөл
Дэд бүрэлдэхүүн хэсгийн нэр	Статистикийн байгууллагын мэдээлэл боловсруулах чадавхыг бэхжүүлэх төсөл
Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
Төслийн дугаар:	5483-MN
Үйл ажиллагааны дугаар:	3.2.7.b Бизнес регистрийн зөвлөх үйлчилгээ
Байрлал:	Монгол Улс, Улаанбаатар хот
Захиалагч:	Үндэсний статистикийн хороо
Гүйцэтгэх хугацаа	5 сар

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийн дагуу Олон улсын хөгжлийн ассоциац нь Ухаалаг засаг төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

Төрийн үйлчилгээний хүртээмж, ил тод байдал, үр ашгийг дээшлүүлэх, мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглахад төслийн хөгжлийн зорилго оршино.

Төсөл нь дараах 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ: а) Иргэний оролцоо, иргэдийн санал хүсэлтийг хангах механизмыг сайжруулах; б) Ухаалаг засгийн газрын суурийг бүрдүүлэх; в) Нээлттэй өгөгдлийг бий болгох; д) Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.

Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар Засгийн газрын хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ), Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (ХХМТГ), Үндэсний статистикийн хороо (ҮСХ) зэрэг байгууллагууд ажиллаж байна.

Үндэсний статистикийн хороо нь энэ төслийн "ҮСХ-ны мэдээлэл боловсруулах чадавхыг бэхжүүлэх" дэд бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд мэдээлэл боловсруулах системийг сайжруулах ажлыг амжилттай хэрэгжүүлж байна. ҮСХ нь Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (GSBPM)-ыг жишиг загвар болгон ашиглах, бизнесийн регистрийн иж бүрэн системийг хөгжүүлэх, төрийн байгууллагуудын хооронд тоон мэдээлэл солилцох төслийн баримт бичгийг боловсруулахаар төлөвлөж байна.

ҮСХ нь аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын 1998 оны тооллогын үр дүнд бизнесийн регистрийн мэдээллийн санг анх байгуулж, аж ахуйн нэгж, байгууллагын тооллого, бизнес регистрийн улирлын мэдээ, эдийн засгийн статистикийн сар, улирал, жилийн мэдээ, тайлан зэрэг албан ёсны статистик мэдээлэл, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон бусад яам, агентлагийн тайлан зэрэг захиргааны мэдээлэлд үндэслэн тогтмол шинэчилж байна.

Түүнчлэн Гадаадын хөрөнгө оруулалтын газрын гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн бүртгэл, Санхүүгийн зохицуулах хорооны банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгал, брокерын байгууллагуудын бүртгэлийг ашиглан бизнес регистрийн санг шинэчилдэг. Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Төрийн өмчийн хороо, Монгол банк, Улсын дээд шүүх зэрэг байгууллагын мэдээллийг ашиглан жил бүр бизнес регистрийн санг шинэчилдэг.

Статистикийн бизнес регистр (СБР)-ийн мэдээллийн сангийн бүтэц нь 1998 оноос хойш хэд хэдэн удаа өөрчлөгдсөн бөгөөд бизнес регистрийн сангийн бүтцэд 2009 онд томоохон өөрчлөлтийг хийж, эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын 4-р хувилбар, засаг захиргааны кодчиллын шинэ системийг нэвтрүүлсэн.

Олон улсын стандартын дагуу статистик нэгжийн мэдээллийн санг 2012 онд байгуулж, дотоод сүлжээнд ашиглах боломж бүрдсэн бөгөөд статистик нэгжийн түүхэн өөрчлөлтийг хөтлөх, мэдээллийг засварлах, өөрчлөх, ашиглах боломжтой цогц программ хангамжийг боловсруулсан. Үүний үр дүнд, ҮСХ, нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн хэрэглэгчид өөрсдийн хүссэн хүснэгт, мэдээллийг үүсгэж, ашиглаж, статистикийн системийн хүрээнд мэдээлэл солилцох боломжийг бодитой болгосон.

Бизнес регистрийг энэ түвшинд хүргэхэд нэлээдгүй ажил хийгдэж байгаа боловч цаашид хийгдэх ажлууд байсаар байна.

ҮСХ нь СБР-ийн дээрх системийг хөгжүүлж, ашиглалтад оруулснаас хойш 5 жилийн хугацаа өнгөрсөн бөгөөд бизнес регистрийн мэдээллийн чанар, мета өгөгдөл, мэдээлэл тархаалт, бизнес регистрийн нууцлалыг сайжруулах шаардлагатай байна. Иймд хэрэглэгчдэд ээлтэй, өндөр хурдтай, орчин үеийн, үүлэн технологид суурилсан, хяналтын самбартай, газар зүйн мэдээллийн системийг нэвтрүүлсэн, одоогийн системийн алдааг сайжруулсан программ хангамжийг хөгжүүлэх шаардлагатай байна.

Цаашид бизнес регистрийн өөрчлөлт, хөдөлгөөнийг хөтлөхөд захиргааны мэдээллийг ашигласан программ хангамжийг хөгжүүлэх ч шаардлага байгаа юм.

Иймд ҮСХ нь бизнес регистрийн өөрчлөлт, хөдөлгөөнийг хөтлөх, ашиглах программ хангамжийг сайжруулан хөгжүүлэх болон захиргааны мэдээллийг санг бизнес регистрийн сантай уялдуулах төслийг баримт бичиг боловсруулах чиглэлээр ажилладаг мэргэшсэн зөвлөх ажиллуулах хүсэлтэй байна.

Зорилго

Зөвлөх үйлчилгээний зорилго нь бизнес регистрийн системийг хөгжүүлэх, бизнес регистрийн мэдээллийн санг төрийн бусад байгууллагуудын мэдээллийн сантай уялдуулах төслийн баримт бичгийг боловсруулахад оршино.

Ажлын хамрах хүрээ

Зөвлөх нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Бизнес регистрийн системийг хөгжүүлэх

- ҮСХ-ны бизнесийн регистрийн системийг судалж, үнэлгээ, шинжилгээ хийнэ.
- СБР-ийн системийг сайжруулах программ хангамж хөгжүүлэх болон төслийн баримт бичиг боловсруулах ажлын хамрах хүрээ, нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, ҮСХ-оор батлуулна.
- Системийн шинжилгээ, үнэлгээ, батлагдсан ажлын хамрах хүрээ, төлөвлөгөөнд үндэслэн бизнес регистрийн программ хангамжийг хөгжүүлж, ҮСХ-нд эх кодын хамт хүлээлгэн өгнө. Шинээр боловсруулах программ хангамж нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
 - Газарзүйн мэдээллийн системийг нэвтрүүлсэн;
 - Хэрэглэгчид ээлтэй;
 - Ажлын хурдыг нэмэгдүүлсэн (онлайн / офлайн орчинд);
 - Мэдээллийн сангийн бүтцийг сайжруулсан;
 - Үүлэн систем / хянах самбарт ажилладаг;
 - Сервер ба сүлжээний хүчин чадлын хамгийн бага түвшинд ашигладаг;
 - Тасалдалгүйгээр ажиллах (холболт тасалдах, хүчин чадал муутай компьютерт ажиллах, буруу мэдээ байршуулах);
 - Ослын нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх боломжтой;
 - Програмын техникийн болон сүлжээний доголдол, алдаа гарсны дараа дахин сэргээх боломжтой;
 - Архивлах, нөөцлөх асуудлыг шийдвэрлэсэн.
- Шинэ боловсруулах СБР-ийн программ хангамжийн хэрэглэгчийн болон

программ хөгжүүлэгчид зориулсан гарын авлагыг боловсруулна.

2. Бизнес регистрийн мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор төрийн бусад байгууллагуудын мэдээллийн сантай уялдуулах иж бүрэн систем хөгжүүлэх төслийн баримт бичиг, удирдамж, мэдээллийн сангийн бүтцийг боловсруулна.
3. Зөвлөх нь ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газрын Бизнес регистрийн алба, Мэдээллийн технологийн газрын ажилтнуудтай хамтран ажиллана.

Программ хангамж хөгжүүлэх үйл ажиллагаа

1. Программ хангамж хөгжүүлэх: Программ хангамжийг хөгжүүлэхдээ дараах алхмуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

Алхам 1. Системд тавигдах шаардлага, техник, технологийн шийдэл, программ хангамжийн дизайныг судлах;

Алхам 2. Программ хангамжийн функциональ, логик / физик дизайныг боловсруулах;

Алхам 3. Программ хангамжийг хөгжүүлж, туршина. Системийн элемент бүрийг дизайны дагуу кодолж, туршиж, туршилтын үр дүнд программ хангамжийг сайжруулах;

Алхам 4. Программ хангамжийг эх кодын хамт ҮСХ-нд хүлээлгэн өгч суурилуулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

Алхам 5. ҮСХ-ны холбогдох ажилтнуудыг доор дурдсан чиглэлээр сургах;

- Программын хэрэглээ,
- Программын орчин, удирдлага, зохицуулалт,
- Программын үндсэн ба дэд интерфэйс орчин,
- Программын тайлагнах систем болон OLAP куб.

2. Программ хангамжийн үндсэн болон дэд систем, тайлан, тархаалтын процессын дараах туршилтуудыг хийнэ.

- а) Интерфэйс туршилт;
- б) Гүйцэтгэлийн туршилт;
- в) Ачаалах туршилт; гэх мэт.

Хүлээгдэж буй үр дүн

Бүх тайлан, материалыг монгол, англи хэл дээр бэлтгэнэ. Зөвлөх нь доор дурдсан бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгнө.

- Зөвлөх нь хөгжүүлсэн системийн хэрэглэгчийн заавар (хэрэглэгч болон программ хөгжүүлэгчид зориулсан), иж бүрэн кодыг ҮСХ-ны Эдийн засгийн статистикийн газар, Мэдээллийн технологийн газарт хүлээлгэн өгнө.
- ҮСХ-ны Мэдээллийн технологийн газар, Бизнес регистрийн албаны ажилтнуудтай хамтран программ хангамжийг туршиж, нэвтрүүлнэ.
- Зөвлөх нь ҮСХ-ны Мэдээллийн технологийн газар, Бизнес регистрийн албаны ажилтнуудад сургалт зохион байгуулна.
- Хэрэглэгчийн заавар, сургалтын гарын авлагыг даалгаврын эцсийн тайлангийн хамт захиалагчид хүргэнэ.
- Зөвлөх нь ажлын явцын талаар Эдийн засгийн статистикийн газрын дарга болон Бизнес регистрийн албанд тогтмол (2 долоо хоног тутам) тайлагнана.
- Зөвлөх нь бизнес регистрийн санг төрийн бусад байгууллагын мэдээллийн сантай уялдуулах төслийн баримт бичгийг Эдийн засгийн статистикийн газарт монгол, англи хэл дээр хүргүүлнэ.

Ажил гүйцэтгэх байр

Ажлыг ҮСХ-ны байранд гүйцэтгэнэ.

Ажлын үргэлжлэх хугацаа

Гэрээ нь ҮСХ, сонгогдсон зөвлөх нь ажил гүйцэтгэх гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба ажлын үргэлжлэх хугацаа 5 сараас хэтрэхгүй байна.

Энэ хугацаа төслийн сүүлчийн даалгавар дуусгавар болсноор дуусах ба 2019 оны 10 сарын 1 өдрөөс 2019 оны 3 сарын 1 өдөр хүртэл үргэлжилнэ.

Байгууллагын зохион байгуулалт

Зөвлөх нь дараах байгууллага, хүмүүстэй хамтран ажиллана.

- ҮСХ нь гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүн хүлээн авах, зөвшөөрөх зэрэг ерөнхий зохицуулалт, хяналтыг хариуцна.
- ҮСХ дахь зохицуулалтын зөвлөх /“Ухаалаг засаг” төслийн ҮСХ-ны мэдээлэл боловсруулалт хүчин чадлыг бий болгох дэд бүрэлдэхүүн хэсэг/ нь гэрээний бичиг баримт бэлтгэх, гэрээнд гарын үсэг зурах, гүйцэтгэх ажлыг зохион байгуулах, үр дүнг цаг хугацаанд дуусгах, Дэлхийн банк, ҮСХ, "Ухаалаг засаг" ТХН-тэй холбогдон хамтран ажиллах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Зөвлөхөд тавигдах шаардлага

Зөвлөх нь дараах шалгууруудыг хангахуйц хувь хүн байна.

- Мэдээллийн технологи, програмчлалын чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй байх;
- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Программ хангамж хөгжүүлэх, газарзүйн нэгдсэн систем боловсруулж байсан туршлагатай;
- Ажлын ачаалах даах, хугацаандаа ажил үүргээ гүйцэтгэдэг байх;
- Англи хэл дээр ажиллах чадвартай;
- Багаар ажиллах чадвартай;
- Статистикийн салбарт ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.